

ХЭРЭГЛЭГЧИЙН КОД:

АХУЙН ХЭРЭГЛЭГЧТЭЙ БАЙГУУЛСАН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

Гэрээг нэг талаас УБЦТС ТӨХК-ийг төлөөлжХэрэглэгчдэд Үйлчлэх Төвийн гэрээний мэргэжилтэн ажилтай овогтой /цаашид **Хангагч** гэх/, нөгөө талаасрегистрийн дугаартайовогтой /цаашид **Хэрэглэгч** гэх/ нар Монгол Улсын “Иргэний хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч- хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, Монгол Улсын стандарт “Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага”-ыг үндэслэн (дүүрэг, аймаг).....-р (хороо, сум)-ын.....-р (хороолол, баг)-ын.....(байр, гудамж) тоот үл хөдлөх хөрөнгө /объект/-ийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор оны сарын –ээс/бичгээр / жилийн хугацаатай дор дурьдсан нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээг үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчтэй байгуулж, гарын үсэг зурж баталгаажуулна. Тус үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч гэрээ баталгаажуулах боломжгүй тохиолдолд итгэмжлэлийн үндсэн дээр хамтран хариуцагчаар гарын үсэг зуруулж болно. Талууд гэрээний нөхцөлийг зөвшөөрч гарын үсэг зурснаар гэрээ байгуулсанд тооцно. Харин үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч, түр оршин суугчтай байгуулах тохиолдолд үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөр давхар гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 1.2 Хамтран хариуцагч, түрээслэгч, түр оршин суугчтай гэрээ байгуулсан тохиолдолд төлбөр тооцооны зөрчил, гэрээтэй холбоотой аливаа асуудлаар үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч нэгэн адил, эрх үүрэг хүлээнэ.
- 1.3 Талууд энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдсон гэрээний нөхцөлд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын “Иргэний хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, Монгол Улсын Стандарт “Цахилгаан хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага” болон бусад хууль, тогтоомжийн заалтуудыг баримтлан шийдвэрлэнэ.
- 1.4 Монгол Улсын MNS IEC 38:2001 стандартын нормативт заасны дагуу “Шугам сүлжээний ажиллагаа хэвийн байх нөхцөлд хэрэглэгчийг тэжээж байгаа цэг дэх хүчдэл нэрлэсэн утгаасаа $\pm 10\%$ -иас илүүгүй хэмжээнд тохируулагдаж байвал зохино”

ХОЁР. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Хэрэглэгч нь эрчим хүчний тухай хуулийн 30 дугаар зүйл, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 5 дугаар зүйл, Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд тус тус зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

- 2.1 Цахилгааны төлбөр төлөх хэлбэр, УБЦТС ТӨХК-ийн харилцдаг банкууд дотроос өөрийн харилцах банкаа сонгож гэрээнд тусгах;
- 2.2 Хангагчийн болон ажилтнуудын үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, гомдлыг УБЦТС ТӨХК-ийн дуудлагын төвийн 70047004, 11342934 утсаар болон Хэрэглэгчдэд Үйлчлэх Төв (ХҮТ), Төв компани, удирдах дээд байгууллага, хууль, хяналтын байгууллагад мэдээлэх, гомдол гаргах;
- 2.3 Гэрээний нэгдүгээр хавсралтаар баталсан эзэмшлийн заагаар цахилгааны шугам сүлжээ, дотор холболт, цахилгаан хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хариуцах, цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжид аюул осол гарч болзошгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд хангагчид нэн даруй мэдэгдэх;
- 2.4 Гэрээний нэгдүгээр хавсралтанд заагдсан хангагч, хэрэглэгчийн хариуцах эзэмшлийн заагаар тодорхойлсон өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээг бүрэн хариуцаж, хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах;

- 2.5 Хангагчийн ажилтны буруугаас илүү төлбөр төлсөн, төлөх нөхцөл байдалд орсон бол цахилгаан эрчим хүчний бичилтийн залруулга хийлгэх, дараа сарын төлбөрт шилжүүлэх;
- 2.6 Хэрэглэгч нь сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрийг түгээх сүлжээнд холбох болон үүсгүүрээсээ түгээх сүлжээнд нийлүүлэх бол заавал техникийн нөхцөлийн дагуу холболтыг хийлгэж, нэмэлт гэрээ байгуулсан байх;
- 2.7 Хэрэглэгч өөрийн тухай мэдээлэл /нүүн шилжсэн, утасны дугаар, и-мэйл хаяг гэх мэт/ хангагчид үнэн зөв өгөх, мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдол бүрт цаг тухайд нь мэдэгдэн заавал өөрчлөлт оруулж байх;
- 2.8 Хангагчийн эрх бүхий ажилтныг тоолуурын заалт авах болон бусад ажлаар өөрийн эзэмшлийн хашаа, үл хөдлөх хөрөнгөнд орох, үйл ажиллагаа явуулахад саад учруулахгүй байх, щитний болон щитэнд нэвтрэх хаалгануудын түлхүүрийг хоногийн 24 цагаар байнгын бэлэн байдалд байлгах;
- 2.9 Хэрэглэгч нь нарийн мэдрэмжтэй тоног төхөөрөмж хэрэглэж байгаа бол гүйдэл, хүчдлийн хэлбэлзлээс хамгаалах төхөөрөмж тавьсан байх;
- 2.10 Эрх бүхий байгууллагаар шалгагдаж битүүмжлэгдсэн тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй, зөөж шилжүүлэхгүй байх;
- 2.11 Өөрийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалгыг жил бүр үнэн, бодитойгоор хангагчид гаргаж өгөх /захиалга өгөөгүй тохиолдолд өмнөх жилийн хэрэглээний захиалгыг мөрдөнө/
- 2.12 Цахилгаан эрчим хүчийг зүй зохистой ашиглаж, хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх, төлбөрөө хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд нэхэмжлэл хүлээн авснаас хойш 3 өдрийн дотор Хэрэглэгчдэд үйлчлэх төвд ирж асуудлаа шийдвэрлүүлэх;
- 2.13 Нөхөн тооцооны төлбөр, алданги, цахилгааны хэрэглээг түдгэлзүүлсэн, цахилгаан хангамжийг сэргээх, бусад үйлчилгээний төлбөр, сануулах, түдгэлзүүлэх болон шүүхэд шилжүүлэх мэдэгдэл хүргэсний хураамжуудыг зохих журмын дагуу төлөх;
- 2.14 Өөрийн эзэмшлийн шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийг цахилгаан эрчим хүчинд холбохгүй байх, суурилагдсан хүчин чадал, хийц, зориулалт, байрлалыг нь дур мэдэн өөрчлөх, өргөтгөхгүй байх;
- 2.15 Цахилгаан сүлжээнээс салгуулах хэрэглэгчийн өргөдлийг шийдвэрлэх шаардлагатай хугацааг хангагчаас хэрэглэгчид хэлж, үйлчилгээний хураамж, тоолуурын заалтыг сүүлийн удаа авснаас хойш таслалт хийгдэх өдөр хүртэлх цахилгааны төлбөрийн зөрүүг урьдчилан төлөх;
- 2.16 3-р зэрэглэлийн /хэрэглэгч/ шугам тоноглолоос тэжээгдэж байгаа хэрэглэгч цахилгаанаар халаалтаа бүрэн шийдсэн тохиолдолд заавал нэмэлт нөөц тэжээлийн эх үүсвэр суурилуулсан байх;
- 2.17 Шугам тоноглолдоо автомат сэлгэн залгагч төхөөрөмж, мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/, сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр суурилуулах бол аюулгүй ажиллагааны үүднээс хангагчид заавал мэдэгдэж бүртгүүлэх;
- 2.18 Гэрээний хугацаа дуусах, өөрчлөлт орох, цикл өөрчлөгдсөн тохиолдолд хангагчийн мэдэгдсэнээр хэрэглэгч Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биеэр ирэх буюу боломжтой бол цахимаар хүсэлт илгээн гэрээнд өөрчлөлт оруулах;
- 2.19 Хэрэглэгч нь суурилагдсан чадлаас хэтэрсэн тоноглол тавьж чадлыг хэтрүүлэхгүй байх;

ГУРАВ. ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

Хангагч нь Эрчим хүчний тухай хуулийн 29 дүгээр зүйл, Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 9 дүгээр зүйл, Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэмд тус тус зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

- 3.1 Авлагатай хэрэглэгчийн цахилгаан эрчим хүч сэргээх захиалгыг хүлээн авахгүй байх;
- 3.2 Цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцох, нөхөн тооцооны төлбөрийг нэхэмжлэх;
- 3.3 Хэрэглэгчдэд үйлчлэх төвд ирж өр төлбөрөө барагдуулах арга хэмжээ авахгүй байх, авлага хэсэгчлэн барагдуулах гэрээний нөхцөл зөрчиж төлбөрөө төлөхгүй байгаа хэрэглэгчийг шүүхэд шилжүүлэх, мөн 3 сар буюу 90 хоногоос дээш хугацаагаар төлбөрөө төлөөгүй хэрэглэгчийн мэдээллийг банкны зээлийн мэдээллийн санд бүртгүүлэх
- 3.4 Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэл, дүүргийн тамгын газар бусад эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг үндэслэн зөрчилтэй хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлэх;
- 3.5 Энэхүү гэрээнд заасан үл хөдлөх хөрөнгийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний төлбөрийг 3 сар дараалан төлөөгүй бол тус үл хөдлөх хөрөнгийг өмчлөгч, эзэмшигчийн бусад дүүрэгт байрлах хангагч байгууллагатай гэрээ бүхий үл хөдлөх хөрөнгийн хаягаар нэхэмжлэх, цахилгаан эрчим хүчний хэрэглээг хязгаарлах эрхтэй;
- 3.6 Хангагч нь зайлшгүй шалтгааны улмаас хэрэглэгчийн бичилт хийлгэх, төлбөр тооцоо хийх циклийн хугацааг өөрчлөх;
- 3.7 Хэрэглэгч эрчим хүчний шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө хариуцах. Хэрэглэгч уг эвдрэл, гэмтлийг засах шаардлагатай арга хэмжээ авахгүй бол хангагч засварыг хийж, гарсан зардлаа хэрэглэгчээс шаардан авах эрхтэй
- 3.8 Хэрэглэгчийн тухай мэдээллийг чандлан хадгалах;
- 3.9 Хэрэглэгч нь түдгэлзүүлсэн шалтгааныг шийдвэрлэн зөрчил устгах арга хэмжээг авч, үйлчилгээний төлбөр хураамжуудыг урьдчилан төлөгдсөн бол хангагч тал хэрэглэгчийн цахилгаан хангамжийг холбогдох журам, стандартад заасан хугацаанд сэргээх;
- 3.10 Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийг гэмтээж, шатаасан бол өөрийн хөрөнгөөр засварлаж сэргээж өгөх; /гэмтэл хохирол тогтоосон актыг үндэслэн/

- 3.11 Ажилтны буруугаас хэрэглэгчийг илүү төлбөр төлүүлсэн, төлөх нөхцөл байдалд хүргэсэн бол алдааг залруулах, дараа сарын төлбөрт шилжүүлэх;
- 3.12 Хэрэглэгчийн бичилт төлбөр тооцооны циклийн хугацааг өөрчилсөн бол энэ тухай төлбөр тооцоо хийх хугацаа болохоос 14 хоногийн өмнө хэрэглэгчид мэдэгдэж, гэрээнд бичгээр өөрчлөлт оруулах;

ДӨРӨВ. ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ

- 4.1 Тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдсан болон цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн болох нь тогтоогдвол Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч-Хэрэглэгч хоорондын “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5 дах хэсгийн холбогдох заалтуудыг үндэслэн нөхөн төлбөр тооцож авна.
 - 4.1.1 Тухайн тооцооны хэмжих хэрэгсэлийн хэвийн ажиллагаа алдагдсан нь хэрэглэгчээс шалтгаалсан эсэхийг Хэмжилзүйн улсын байцаагчийн дүгнэлт болон эрх бүхий тоолуурын лабораторийн дүгнэлтээр тогтооно;
 - 4.1.2 Зүй бусаар цахилгаан эрчим хүчийг хэрэглэснийг хангагч талын ажилтан баримт бүрдүүлэн нотолсон байна;
- 4.2 Эзэмшлийн зааг дээр тоолуур тавиагүй тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх шугам сүлжээний алдагдлыг эзэмшигч хүлээнэ.;
- 4.3 Төлбөрийн нэхэмжлэлд цахилгаан эрчим хүчний төлбөр тусгагдахаас гадна нөхөн тооцооны төлбөр, хугацаа хэтрүүлсний алданги, дараа төлбөрт үйлчилгээ үзүүлсэн бол үйлчилгээний төлбөр хураамж, НӨАТ, телевиз, хог хаягдлын хураамжийн төлбөрүүд бусад нэмэлт төлбөрүүд тусгагдсан байна;
- 4.4 Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө урьдчилан төлж болно;
- 4.5 Хэрэглэгч нь хангагчийн төлбөрийн нэхэмжлэл банкинд хүргэгдсэнээс хойш гэрээнд заасан хугацаанд нэхэмжилсэн төлбөрийг төлөх бөгөөд энэ хугацаанд төлбөрөө төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам 0.3% -ийн алданги төлнө;
- 4.6 Байр, орон сууц, хашаа, газар өмчлөгч, эзэмшигч иргэн нүүхдээ цахилгаан эрчим хүч хэрэглэсэн тооцоогоо хийж дуусгаж, энэ тухай тодорхойлолтыг хангагчаас авсан байна. Энэ тодорхойлолтыг тухайн байр, орон сууц, хашаа, газрыг шинээр өмчлөгч, эзэмшигч иргэн, хуулийн этгээд шаардаж авна. Хэрэв уг тодорхойлолтыг аваагүй тохиолдолд шинээр өмчлөгч, эзэмшигч эрчим хүчний өрийг хариуцна;
- 4.7 Хангагчтай гэрээ байгуулсан үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч нас барсан, 3 ба түүнээс дээш сараар удаан хугацаагаар нүүн шилжихдээ хангагчид мэдэгдээгүй, үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч нь цахилгаан хэрэглэсэн төлбөрөө барагдуулалгүй нүүн шилжсэн тохиолдлуудад энэхүү гэрээний 1.2, 1.3-д заасны дагуу үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч төлбөр тооцооны зөрчил гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцан барагдуулна;
- 4.8 Хангагч нь цахилгаан сүлжээнээс салгуулах хүсэлтийг шийдвэрлэхэд шаардлагатай хугацааг хэрэглэгчид хэлж, хэрэглэгч нь үйлчилгээний хураамж болон тоолуурын заалтыг сүүлийн удаа авсанаас хойш таслалт хийгдэх өдөр хүртэлх цахилгааны төлбөрийн зөрүүг урьдчилан төлнө;
- 4.9 Хэрэглэгч өөрийн тоолуур хэмжих хэрэгсэлд хангагчийн ажилтныг нэвтрүүлээгүй, заалт авах нөхцөлөөр хангаагүй бол тухайн сарын хэрэглээг сүүлийн 3 сарын хэрэглээний дунджаар тооцох ба 2 сар дараалан нэвтрүүлээгүй тохиолдолд хангагч талаас цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ
- 4.10 Цахилгаан зарцуулалтын төлбөр тооцоог хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ЭХЗХ-ны Зохицуулагчдын Зөвлөлөөс баталсан хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифаар, үйлчилгээний төлбөрийг ЭХЗХ-ны болон хангагч байгууллагын баталсан үнэ тарифаар тус тус хийнэ.

ТАВ. ТООЦООНЫ ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 5.1 Тооцооны хэмжих хэрэгсэл хэний өмч байхаас үл хамаарч, тухайн тоолуур хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тоолуур хэмжих хэрэгсэлийн цитийг суурилуулсан байрны өмчлөгч, эзэмшигч хариуцна; Тооцооны хэмжих хэрэгсэл алдагдсан, гэмтсэн тохиолдолд тооцооны хэмжих хэрэгсэл суурилуулах, гэмтэл устгахтай холбогдон гарах зардлыг хариуцагч гаргана;
- 5.2 Хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслийг хангагч өөрийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгслээр солих хүртэлх хугацаанд хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслээр цахилгаан эрчим хүчний хэрэглээг тооцож болох бөгөөд тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна;
- 5.3 Тооцооны хэмжих хэрэгслийг баталгаажуулахтай холбогдон гарах зардлыг өмчлөгч, эзэмшигч өөрөө хариуцна;
- 5.4 Баталгаажуулах хугацаанаас өмнө хэрэглэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдаж баталгаажуулах шаардлагатай болсон эсвэл хэрэглэгчийн хүсэлтээр тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагааг шалгаж баталгаажуулах тохиолдолд хэрэглэгч үйлчилгээний хураамжийг урьдчилан төлөх үүрэг хүлээнэ;
- 5.5 Хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах явцад тооцооны хэмжих хэрэгслийг оролдсон, гэмтээсэн шинж тэмдгүүдийг илрүүлсэн бөгөөд үүнд хэрэглэгчийн үйлдэл гарцаагүй нөлөөлсөн гэдгийг тогтоосон бол энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж хангагчийн эрх бүхий ажилтан акт үйлдэн, тооцооны хэмжих хэрэгсэл гэмтэлтэй байсан хугацаанд ногдох дутуу тооцсон цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцож нэхэмжилнэ;
- 5.6 Хангагчийн эзэмшлийн дэд станц, нэгдсэн шитэнд байрласан тоолуур хэмжих хэрэгслийн битүүмжлэл алдагдсан, дутуу тоолсон, эвдэрсэн гацсан алдагдсан бол энэхүү гэрээний 4.1 зүйлийг баримтлан дутуу тооцогдсон эрчим хүчийг нөхөж тооцно.

- 5.7 Тоолуур баталгаажуулах, солих үеийн тоолуургүй хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний тооцоог хэрэглэгчийн сүүлийн 3 сарын дундаж хэрэглээг тоолуургүй байсан өдрийн тоогоор үржүүлэн тооцож авна;
- 5.8 Тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг санаатайгаар удаа дараа алдагдуулж хангагчийн шаардлагыг биелүүлээгүй хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах ба шүүхийн байгууллагад шилжүүлнэ;
- 5.9 Орон сууцны хэрэглэгчийн тоолуурыг давхар дундын нэгдсэн цитэнд, амины орон сууц, гэр хорооллын хэрэглэгчийн тоолуурыг гадна нэгдсэн цитэнд байрлуулах ба хэрэглэгч гэр, граж, агуулах, зоорийн давхар дотроо тавихыг хориглоно;

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Цахилгаан эрчим хүчний тасалдал, чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс болж хангагчтай гэрээтэй хэрэглэгчид хохирол учруулсан тохиолдолд 24 цагийн дотор хэрэглэгч нь хангагчид мэдэгдэж, хамтарсан акт үйлдэн гаргасан шийдвэрийг үндэслэн хохирлыг буруутай тал төлнө;
- 6.2 Цахилгаан эрчим хүчний тасалдлаас учирсан хохирлыг дор дурьдсан тохиолдолд хангагч хариуцахгүй.
 - 6.2.1. Байгалийн гэнэтийн аюул /аянга, салхи, шуурга, мөстлөг, үер, гал түймэр гэх мэт/ тохиолдсон;
 - 6.2.2. Хангагчтай тохиролцсон горимыг хэрэглэгч мөрдөөгүйгээс хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдсан;
 - 6.2.3. “Эрчим хүчний тухай хууль”-ийн 29.1.2, 32.1, 32.2-т заасны дагуу хэрэглэгчийн цахилгаан хангамжийг тасалсан, түдгэлзүүлсэн;
 - 6.2.4. Хэрэглэгчийн цахилгаан дамжуулагч шугамыг гуравдагч этгээд гэмтээж эрчим хүчээр тасалдуулсан;
 - 6.2.5. Гэрээний 2.3, 2.8, 2.13, 2.14, 2.15, 2.18-д заасныг зөрчсөнөөс болон хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан тасралт, саатал, гэмтэл гарсан, түүнээс үүдэн цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлсэн;
 - 6.2.6. Цахилгаан эрчим хүчний бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанаас шалтгаалсан аваари, осол болон саатал гарсан;
 - 6.2.7. Хангагч талын өмчлөлд холбогдох тогтоол шийдвэрийн дагуу хүлээлгэн өгөөгүй байгаа болон хэрэглэгч өөрөө эсвэл гуравдагч этгээд ашиглалт засвар, үйлчилгээг нь хариуцаж байгаа дэд станц, барилгын 0,4 кВ-ын кабель шугам, цахилгаан тоноглолд гарсан гэмтэл, саатал;
- 6.3 Хэрэглэгч өөрийн буруутай үйлдэл, мөн өөрийн өмчлөлийн буюу эзэмшлийн гэрийн тэжээвэр амьтдыг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хангагчийн ажилтанд хохирол учруулсан бол бодит гарсан хохирол, эмчилгээний зардал, бусад хохирлыг хэрэглэгч хариуцна;
- 6.4 Зар, мэдээлэл сануулгыг хэрэглэгчийн гэрээнд заасан утасны дугаарт мессежээр хүргүүлэх бөгөөд холбоо барих утасны дугаар өөрчлөгдсөнийг хангагч талд албан ёсоор мэдэгдээгүй болон мессеж хүргэх үед гар утасны оператор компаниудын үйл ажиллагаа саатсан, хэрэглэгчийн утас сүлжээгүй, унтарсан байснаас мэдэгдэл мессеж очоогүйгээс гарах хохирлыг хангагч тал хариуцахгүй;
- 6.5 Хэрэглэгч нь ямар нэгэн төлбөрт үйлчилгээг хангагчтай зөвшилцөж албан ёсны үйлчилгээ авалгүй хангагчийн ажилтантай хэлцэл хийж, ажил үйлчилгээ авсан бол үүнээс үүдэн гарах хохирлыг хангагч тал хариуцахгүй;
- 6.6 Хэрэглэгч нь 2.17-д заасны дагуу гэрээнд өөрчлөлт оруулаагүй бол тухайн өөрчлөлтүүдийг мөрдөхгүй байх үндэслэл болохгүй.
- 6.7 Гэрээний 2.6-д заасан мэдээллийг хангагч талд өгөөгүйгээс үүдэн гарах аливаа асуудал, хохирлыг хэрэглэгч бүрэн хариуцна;
- 6.8 Хэрэглэгч өөрийн хэрэглээнээс зөвшөөрөлгүй нэмж хэрэглэгч холбох, стандартын шаардлага хангаагүй тоног төхөөрөмж, цахилгааны кабель, утас хэрэглэх зэргээс шалтгаалж хүчдлийн түвшин багасах болон түүнээс үүдэн гарах бусад хохирол болон хангагч талын тоног төхөөрөмж, кабелийг гэмтээсэн бол хохирлыг хэрэглэгч бүрэн хариуцна

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Талууд аливаа маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Хэрэв харилцан тохиролцож шийдвэрлэж чадахгүй бол асуудлыг дараах байдлаар шийдвэрлүүлнэ.
 - 7.1.1 Хангагч, хэрэглэгч талуудын хооронд гарсан маргаантай асуудал нь Эрчим хүчний тухай хуулийн 35.1-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэн эрх мэдэлд хамаарах бол тус хороонд гаргаж шийдвэрлүүлнэ; /үүнд эрчим хүчний үнэ тариф, түүнийг тооцох аргачлал, цахилгаан тоног төхөөрөмж, хангагчийн үйл ажиллагаатай холбоотой асуудлууд хамаарна/
 - 7.1.2 Хэрэглэгч өөрийн хэрэглэсэн эрчим хүчний төлбөрөө гэрээний хугацаандаа төлөөгүйгээс авлага үүсгэсэн, төлөхөөс зайлсхийсэн, хангагч талтай байгуулсан авлага хэсэгчлэн барагдуулах гэрээний үүргээ зөрчсөн бол албадан төлүүлэх зорилгоор шууд харъяа шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлнэ;

НАЙМ. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ДҮГНЭХ, ЦУЦЛАХ

- 8.1 Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журамд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө шинэчлэн байгуулж болно;
- 8.2 Хангагч, хэрэглэгч талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү өөрчлөлтийг бичгээр үйлдэж гэрээнд тусган баталгаажуулна;
- 8.3 Хангагч, хэрэглэгчийн хоорондын эзэмшлийн зааг, техникийн нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд талууд эзэмшлийн заагийг тодорхойлсон хавсралтанд нэмэлт өөрчлөлт оруулна;

- 8.4 Хангагч, хэрэглэгч хоорондын эзэмшлийн заагийг тодорхойлсон НЭГДҮГЭЭР хавсралт, хэрэглэгчийн төлбөр төлөх хэлбэр, төлбөрийн хугацааг тодорхойлсон ХОЁРДУГААР хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна;
- 8.5 Гэрээнд болон хавсралтуудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хангагч хэрэглэгчид мэдэгдэх бөгөөд заасан хугацаанд хэрэглэгч гэрээнд болон хавсралтад оруулсан нэмэлт өөрчлөлттэй танилцаж баталгаажуулаагүй бол уг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй;
- 8.6 Хэрэглэгч гэрээ дуусахаас нэг сарын өмнө хангагчтай тооцоо нийлж, гэрээг дүгнэсэн протокол үйлдэнэ;
- 8.7 Гэрээг хоёр хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Талуудын хадгалсан хувь тус бүр нь нэгэн адил хүчин төгөлдөр байна;
- 8.8 Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг хуульд зааснаас гадна дараах нөхцөлд хугацаанаас нь өмнө цуцална.
- 8.8.1 Аль нэг талын санаачилгаар;
- 8.8.2 Хэрэглэгч гэрээний үүргээ зөрчсөн, хангагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй, эрх бүхий байгууллагын /хууль, шүүхийн болон мэргэжлийн хяналт болон бусад/ эцсийн шийдвэрээр цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлж гэрээг цуцлах тухай шийдвэр, тогтоол гарсан;
- 8.8.3 Тоолуур хэмжих хэрэгслийг хангагч байгууллагад мэдэгдэлгүй дур мэдэн солих, холболтыг өөрчлөх, битүүмжлэлийг алдагдуулах үйлдлийг 3-аас дээш удаа үйлдсэн нь нотлогдвол нэг талын санаачилгаар гэрээг дуусгавар болгоно.
- 8.9 Гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө талууд гэрээ цуцлах санал гаргаагүй болон хэрэглэгч төлбөрийн зөрчилгүй байвал гэрээг анх заасан хугацаагаар гэрээ дүгнэсэн протоколыг үндэслэн сунгана. Гэрээний 8.5-д заасан үүргээ биелүүлж гэрээний хугацаа сунгасан, дүгнэсэн протоколд хэрэглэгч гарын үсэг зураагүй бол хангагч тал дангаар гэрээг сунгаж баталгаажуулна. Энэ тохиолдолд гэрээний хугацааг сунгагдсанд тооцож, хүчин төгөлдөр гэрээ гэж үзнэ.
- 8.10 Өр төлбөрийн үлдэгдэлтэй хэрэглэгчийн гэрээг цуцлахгүй.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

ХАНГАГЧ

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийн дарга _____

.....(гарын үсэг)

ХҮТ-ийн _____ ажилтан

.....(гарын үсэг)

Утас: _____

Хаяг _____

ХЭРЭГЛЭГЧ

_____ -д ажилтай

_____ овогтой _____

.....(гарын үсэг)

Хамтран хариуцагч

_____ овогтой _____

.....(гарын үсэг)


Түрээслэгч

_____ овогтой _____

.....(гарын үсэг)

Хангагч, хэрэглэгч хоорондын эзэмшлийн зааг

1. Талуудын эзэмшлийн заагийг хувилбараар тогтоов.
 Хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн суурилагдсан чадал _____кВТ
 Гэрэлтүүлгийн чадал _____кВТ
 Нийлбэр чадал _____кВТ
 Хүчдлийн түвшин 220В



Эзэмшлийн зааг бичиглэлээр: _____

2.1 Цахилгаан эрчим хүчний тооцоо, төлбөр хийх хугацаа

Хэрэглэгчийн ангилал _____

Халаалтын ангилал _____

Борлуулалтын цикл _____

Үнэ тарифын ангилал _____

д/д	Агуулга	Хуанлийн өдрүүд
1	Сар бүрийн тоолуурын заалт авах өдөр	
2	Төлбөрийн нэхэмжлэл банк болон ХҮТ-ийн төлбөр төлөх цэгүүдэд очсон байх өдөр	
3	Тухайн сарын цахилгааны төлбөрөө төлсөн байх сүүлийн өдөр	
4	Алданги тооцож эхлэх өдөр	
5	Сануулах, түдгэлзүүлэх мэдэгдэл хүргэгдэх өдөр	
6	Эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлж эхлэх өдөр	

2.2 Хэрэглэгчийн сонгосон банк

_____ банк _____ дансны дугаар

2.3 Хэрэглэгчийн төлбөр төлөх хэлбэр

- Дансаар..... /дансны дугаар/
- Картаар /биллинг/..... /картны дугаар/
- Бэлнээрбанк болон УБЦТС ТӨХК-ийнХҮТ-ийн кассанд төлнө.
- Интернэтээр.....

2.4 Хэрэглэгчийн мэдээлэл авах хаяг /сануулах, түдгэлзүүлэх мэдэгдэл, төлбөртэй холбоотой бусад мэдээлэл/, НӨАТ-ын буцаан олголт, төлбөрийн нэхэмжлэл илгээх мэдээлэл. Хэрэглэгчийн утасны дугаар, и-мэйл хаяг, и-баримтын дугаар өөрчлөгдөх бүрт хангагчид мэдэгдэж гэрээнд тусгуулах ба мэдэгдээгүй улмаас үүдэн гарах хохирлыг хангагч хариуцахгүй.

Мессеж очих утасны дугаар _____ Бусад утасны дугаар _____

Хэрэглэгчийн и-мэйл хаяг _____ И-баримтын дугаар _____

Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний захиалга: он

Хугацаа /сар/	Захиалга /кВт.ц/	Хугацаа /сар/	Захиалга /кВт.ц/
1 сар		7 сар	
2 сар		8 сар	
3 сар		9 сар	
Улирлын дүн		Улирлын дүн	
4 сар		10 сар	
5 сар		11 сар	
6 сар		12 сар	
Улирлын дүн		Улирлын дүн	
Эхний хагас жилийн дүн:		Сүүлийн хагас жилийн дүн:	
Жилийн дүн:			

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

.....
.....
.....
.....
.....
.....
.....

ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН:

ХАНГАГЧ

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийн дарга _____

.....(гарын үсэг)

ХҮТ-ийн _____ ажилтан

.....(гарын үсэг)

Утас: _____

Хаяг _____

ХЭРЭГЛЭГЧ

_____ -д ажилтай

_____ овогтой _____

.....(гарын үсэг)

Хамтран хариуцагч

_____ овогтой _____

.....(гарын үсэг)

Түрээслэгч

_____ овогтой _____

.....(гарын үсэг)

..... оны дугаар сарын

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

.....
.....
.....
.....
.....
.....
.....

ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН:

ХАНГАГЧ

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийн дарга _____

.....(гарын үсэг)

ХҮТ-ийн _____ ажилтан

.....(гарын үсэг)

Утас: _____

Хаяг _____

ХЭРЭГЛЭГЧ

_____ -д ажилтай

_____ овогтой _____

.....(гарын үсэг)

Хамтран хариуцагч

_____ овогтой _____

.....(гарын үсэг)

Түрээслэгч

_____ овогтой _____

.....(гарын үсэг)

..... оны дугаар сарын

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ №

.....онсарөдөр

Улаанбаатар хот

Гэрээний биелэлтийн байдалд өгөх дүгнэлт:

.....
.....
.....
.....
.....
.....
.....

Шийдвэрлэсэн нь:

.....
.....
.....
.....
.....
.....
.....

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН:

ХАНГАГЧ

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийн дарга _____

.....(гарын үсэг)

ХҮТ-ийн _____ ажилтан

.....(гарын үсэг)

Утас: _____

Хаяг _____

ХЭРЭГЛЭГЧ

_____ -д ажилтай

_____овогтой _____

.....(гарын үсэг)

Хамтран хариуцагч

_____овогтой _____

.....(гарын үсэг)

Түрээслэгч

_____овогтой _____

.....(гарын үсэг)